	3. Улаанбаатур олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулна.	Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/322 дугаар захирамжаар дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, монгол аялагчдад эх орны байгалийн үзэсгэлэнт газрууд, түүх соёлын дурсгалт газруудын талаар нэгдсэн мэдээлэл олгох, зөв зохистой аялах, ямар маршрутаар хаашаа, яаж аялах талаар зөвлөмж олгох зорилготой үндэсний аялал жуулчлалын “Улаанбаатар-2017” үзэсгэлэнг 3 дахь жилдээ Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улаанбаатар аялал жуулчлалын холбоотой хамтран 2017 оны 6 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулав. Үзэсгэлэнд ОХУ, БНСУ, АНЭУ, БНЭУ-ын элчин сайдын яам, Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий			Бодлого төлөвлөлтийн хэлтэс
Арга хэмжээний удирдамж, төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулах, батлуулах					
Батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг хангаж, арга хэмжээг зохион байгуулах					
Арга хэмжээний үр дүн, мэдээллийг олон нийтэд түгээж, илтгэх хуудас,					

		тайланг холбогдох газарт хүргүүлэх	аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газрууд, жуулчны бааз, рашаан сувиллын газрууд болон Хил хамгаалах ерөнхий газар, Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ, “Төрийн банк”, “Юнител” компани, Монголын Уулчдын үндэсний холбоо, Монголын Рафтингийн холбоо, Аялал жуулчлалын Боловсрол хөгжлийн нийгэмлэг зэрэг мэргэжлийн холбоодууд, тур оператор компаниуд, аялал жуулчлалын төсөл хөтөлбөрүүд зэрэг 80 гаруй байгууллага оролцож дотооддоо аялах аяллын маршрут, зөвлөгөө мэдээлэл, гадаад улс орон руу аялах амарч зугаалахтай холбогдсон мэдээ мэдээллийг өгч, аяллын холбогдолтой бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ иргэдэд танилцууллаа. Мөн үзэсгэлэнгийн үеэр иргэд аялагчдад зориулан Монголын Үндэсний их сургуулийн багш, судлаач, доктор профессор О.Сүхбаатар Монгол улсын хүрхрээг үзэж судлах аялал, Монголын Уулчдын үндэсний холбооны дэд ерөнхийлөгч С.Алдаршиг Дугуйн аялал, уулын спорт гайхамшигийн талаар, Монголиан гайд тур компанийн захирал Ч.Буянбадрах Гадаадад аялахад хэрхэн бэлтгэх талаар, гэрэл зурагчин Л.Жаргал Аяллын үеэр шувуу, амьтны зургийг хэрхэн авах вэ?, Монголын Цайны замын холбооны дэд тэргүүн Ш.Эгшиг Монголын нууц товчоо сэдэвт аяллын талаар илтгэлүүд тавьлаа. Энэ жилийн үзэсгэлэнгийн шилдгийн шилдэг орлогчоор “Төрийн банк”, өвөрмөц тохижилттой оролцогчоор ОХУ-ын Шинжлэх ухаан соёлын төв “РЦНК” шалгарлаа. Үзэсгэлэнг нийт 8000 гаруй иргэн үзэж сонирхлоо.		
		4. “Талын салхи” мотоциклчдын парадын зохион байгуулалтад оролцох Батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг хангаж, арга хэмжээг хамтран зохион байгуулах	Санхүүжилт байхгүй улмаас 2018 онд хийхээр төлөвлөж байна.	Мэдээлэл сурталчилгааны хэлтэс	-
1.4.10. Жуулчдын тоог нэмэгдүүлэх, тэдэнд	1. “Шөнийн Улаанбаатар”	Хөтөлбөрийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулах,	“Шөнийн Улаанбаатар” хөтөлбөрийн төсөл боловсруулж байна.	Бодлого төлөвлөл-	10%

зориулсан “Шөнийн Улаанбаатар” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.	хөтөлбөр боловсруулан батлуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.	хөтөлбөрт тусгагдсан ажлуудын төсвийн төслийг боловсруулах		ТИЙН ХЭЛТЭС	
		Хөтөлбөрийг Засаг даргын удирдлагын зөвлөлд танилцуулж НИТХ-аар батлуулах			
2. "Олон үндэстний хоолны гудамж" арга хэмжээг зохион байгуулна.		Батлагдсан хөтөлбөрийн дагуу төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлж эхлэх	2017 оны 09 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөж байна.	Бодлого төлөвлөлтийн хэлтэс	-
		Арга хэмжээг зохион байгуулах удирдамж, төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулах, батлуулах			
		Батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг хангаж, арга хэмжээг зохион байгуулах			
		Арга хэмжээний үр дүн, мэдээллийг олон нийтэд түгээж, илтгэх хуудас, тайланг холбогдох газарт хүргүүлэх			
<b>Байгууллагын дотоод ажил үйлчилгээг сайжруулах чиглэлээр:</b>					
Байгууллагын дотоод зохион байгуулалтыг сайжруулна.		1. Нийслэлийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврыг биелэлтийг хангуулж ажиллах, хяналт тавих	Нийслэлийн Удирдах ажилтны шуурхай зөвлөлгөөнөөс өгсөн үүрэг даалгаврыг танилцуулж, нийт 11 удаагийн шуурхай зөвлөгөөний тус газартай холбоотой 27 үүрэг даалгаврын биелэлтийг цаг тухай бүрт гарган НЗДТГ-ын ХШҮХ-т цахимаар хүргүүлэв.	Захиргааны хэлтэс	50%
		2. Удирдлагуудын иргэдтэй уулзсан талаарх тайланг гарган холбогдох газарт хүргүүлэх	Тус Газрын дарга болон Орлогч дарга иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай хийсэн уулзалтын 1 дүгээр улирлын тайланг 2017 оны 03 дугаар сарын 27-ны 01/118 албан тоотой, 2 дугаар улирлын тайланг 07 дугаар сарын 04-ны өдрийн 01/284 албан тоотой Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлэв.		
		3. Тус газраас үзүүлж буй	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл		

		төрийн үйлчилгээний чанар, ажилтан, албан хаагчдын мэргэжил, ур чадвар, харилцааны түвшинг үнэлэх сэтгэл ханамжийн судалгаа авах, үр дүнг тайлагнах	ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 63%, Монгол Улсын Засгийн газрын тогтоолын биелэлт 30%, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт 58%, НИТХ-ын 2016 оны 5/10 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт 74%, НИТХ-ын 2017 оны тогтоолын биелэлт 50%, НИТХТ-ийн 2017 оны тогтоолын биелэлт 70%, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 77%, нийт дээд газрын шийдвэрийн биелэлтийг цахимаар, цаасаар гарган тайлан мэдээг НЗДТГ-т цаг хугацаанд нь хүргүүлэв.		
		4. Шинээр ажилд орж байгаа ажилтнуудыг ажилд томилуулахаар нэр дэвшүүлэх, тангараг өргүүлэх	2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/40 тоот албан бичгээр НДТАЗСЗ-д Орлогч дарга, Захиргааны хэлтсийн дарга, Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн дарга нарыг нэр дэвшүүлэхээр саналыг хүргүүлдсэн. НДТАЗС 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 35 дугаар тогтоолын дагуу газрын даргын Б/26, Б/27, Б/28, Б/29 дүгээр тушаалаар тус тус томилсон. НДТАЗСЗ-ийн 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 15/125 дугаар албан бичгийн дагуу Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан Г.Азжаргалыг газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Б/33 дугаар тушаалаар томилсон.		
		5. Шинээр батлагдсан хууль, тогтоомж, журмыг нийт ажилтан, албан хаагчдад танилцуулах	Дээд газраас болон хэрэгжүүлэгч агентлагаас зохион байгуулагдсан ажил үүрэгтэй холбоотой дүрэм журмын талаарх сургалтуудад давхардсан тоогоор нийт 33 албан хаагчид оролцсон. 2017 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/05 дугаар тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж батлуулан албан хаагчдад танилцуулан мөрдөж ажиллаж байна.		
		6. Байгууллагын ёс зүйн хороо, Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг байгуулж үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг боловсруулан батлуулж	Байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороог газрын даргын А/06 дугаар тушаалаар шинэчилэн баталсан. Ёс зүйн хороо 2017 оны 04-р сарын 10-ны өдөр хуралдаж Нийслэлийн Аялал жуулчлалын газрын ёс зүйн хорооны 2017 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэж газрын даргаар батлуулсан.	Захиргааны хэлтэс	

		хэрэгжилтийг хангаж ажиллах, тайлагнах			
		7. Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх, архивын баримтын талаарх мэдээ тайланг цаг хугацаанд гаргаж, тайлагнах	2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 2016 оны Байгууллагын архивын ажлын мэдээ, Албан хэрэг хөтлөлтийн тоон тайлан болон Хүний нөөцийн бүртгэлийг тоон тайланг цахим хэлбэрээр <a href="http://tailan.ub.gov.mn">tailan.ub.gov,mn</a> цахим хуудсаар хүргүүлэв.		
		8. Байгууллагын 2016 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн нийслэлийн удирдлагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, биелэлтийг гарган холбогдох газарт хүргэх	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2016 оны байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын талаар нийслэлийн удирдлагын зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн дагуу хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдөр газрын даргаар батлуулж төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд нийт 22 ажил хийхээр тусгагдсан. Зөвлөмжийн биелэлт гарах хугацаа болоогүй.		
	Даргын зөвлөлийн болон газрын хурлыг зохион байгуулна.	1. Газрын хурлын тэмдэглэл хөтөлж өгсөн үүрэг даалгаврыг нийт албан хаагчдад мэдээлэх	2017 оны эхний хагас жилийн байдлаар 03 дугаар сарын 03-ны өдөр, 04 дүгээр сарын 11-ний өдөр, 05 дугаар сарын 08-ны өдөр нийт 3-н удаа газрын хурал болсон. Хурлын үеэр тэмдэглэл хөтөлж газрын даргын өгсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь албан хаагчдад мэдээллэв.	Захиргааны хэлтэс	50%
		2. Даргын зөвлөлийн хурлыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөх, хурлаас гарсан шийдвэрийг нийт албан хаагчдад танилцуулах	2017 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр газрын даргын зөвлөлийн хурал болов. Тус хуралд газрын дарга, орлогч дарга болон 4-н хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид оролцон нийт 9 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, албан хаагчдад танилцуулав.	Захиргааны хэлтэс	
		3. Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган даргын зөвлөлийн хуралд танилцуулах	Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулан баталж, биелэлтийг хагас жилийн байдлаар гарган 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн, НЗДТГ-т хүргүүлэв.	Захиргааны хэлтэс	
	Цаг үеийн ажлын шаардлагаар дээд газраас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг	1. Үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй цаг үеийн ажлын шаардлагаар дээд газраас өгсөн үүрэг	Үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй цаг үеийн ажлын шаардлагаар дээд газраас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган тайлан мэдээг цаг тухай бүр холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллав.	Бүх хэлтсүүд	50%

	хангаж ажиллана.	даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах, цаг хугацаанд нь холбогдох газарт тайлан мэдээг хүргүүлэх			
		2. Дээд газрын тогтоол, шийдвэр, захирамжлалын баримт бичгийн биелэлтийг гаргаж холбогдох газарт хүргэх	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 63%, Монгол Улсын Засгийн газрын тогтоолын биелэлт 30%, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт 58%, НИТХ-ын 2016 оны 5/10 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт 74%, НИТХ-ын 2017 оны тогтоолын биелэлт 50%, НИТХТ-ийн 2017 оны тогтоолын биелэлт 70%, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 77%, нийт дээд газрын шийдвэрийн биелэлт 60% -тай байгааг гарган тайлан мэдээг НЗДТГ-т хүргүүлэв.	Захиргааны хэлтэс	
		3. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах, холбогдох газарт тайлагнах	НЗДТГ-аас 2017 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 04/2322 тоот албан бичгээр Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг ирүүлсэн ба уг төлөвлөгөөний дагуу байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргад танилцуулаад байна.		
		4. Байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах, хяналт тавих, тайлагнах	НЗД-ын 2012 оны А/651, 606 дугаар захирамжийн дагуу байгууллагын цахим хуудсын мэдээллийг шинэчлэн шинэ батлагдсан журам, төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолтыг оруулсан. Албан хаагчдын холбоо барих утас, и-мэйл хаяг болон зургийг байгууллагын цахим хуудсанд байрлуулж, өөрчлөлт орсон тухай бүр шинэчилж ажилласан. Газрын цахим дотоод группд ажилтнуудад мэдээлэл өгч, санал авч ажиллаж байна.		
	Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар	1. Ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавих, хариуцлага тооцож ажиллах	Албан хаагчдын цаг ашиглалт, ажлын цагийн тооцоог сар бүрийн 1, 15-ны өдрүүдэд гарган албан хаагчдад болон хэлтсийн дарга нарт танилцуулан ажиллаж байна. Тус газрын нийт 3 албан хаагч өвчтэй эмнэлэгийн хуудас авчиран ахлах нягтлан бодогчид		50%

			өгсөн. Нийтийг хамарсан ажилд бүх албан хаагчид идэвхитэй оролцон ажиллаж байна.	Захиргааны хэлтэс	50%
		2. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж байна.		
		3. Үр бүтээлтэй ажилласан ажилтнуудын судалгаа гаргаж зэрэг дэв олгуулах талаар удирдлагуудад санал оруулах, зэрэг зэвийг олгуулах	Нийслэлийн Засаг даргын 2017 оны Зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай А/171 дүгээр захирамжын дагуу газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн Б/18 дугаар тушаалаар нийт 3 албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдлийг олгов.		
		4. Үр бүтээлтэй ажиллаж буй ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулах	Газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн Б/17 дугаар тушаалаар 1 албан хаагчид ур чадварын нэмэгдлийг олгож эхэлсэн. Аялал жуулчлалын салбарт идэвхи санаачилга, бүтээлч байдлыг гарган ажиллаж буй Захиргааны хэлтсийн дарга Д.Ганболдыг төрийн дээд шагнал Хөдөлмөрийн хүндэт медаль, Орлогч дарга Ц.Энхтүвшинг “Хөдөлмөрийн гавьяаны удаан тугийн одон”-гоор тус тус шагнуулав.		
		5. Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөлийг хангах үүднээс компьютер, хувилагч машин, бичиг хэргийн хэрэгслээр хангах	Санхүүжилт байхгүй тул шийдвэрлээгүй байна.	Захиргааны хэлтэс	
Албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх талаар		1. Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх үүднээс дээд газраас зохион байгуулж сургалтад хамруулах	Дээд газраас болон хэрэгжүүлэгч агентлагаас зохион байгуулагдсан ажил үүрэгтэй холбоотой дүрэм журмын талаарх сургалтуудад давхардсан тоогоор нийт 33 албан хаагчид оролцсон.	Захиргааны хэлтэс	
		2. Аялал жуулчлалын чиглэлээр гадаад, дотоодод урт, богино хугацааны сургалт, олон улсын уулзалт, семинарт албан хаагчдыг хамруулах	НЗДТГ-аас БНСУ-ын Пусан хотын захиргаанаас нутгийн засаг, захиргааны байгууллагуудыг ажилтнуудын “K2H” солилцооны 6 сарын хөтөлбөрт тус газрын 1 мэргэжилтэн Б.Амарзаяа хамрагдаж байгаа.		
		3. Ажилтан, албан	Хугацаа болоогүй		

		хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх ажил зохион байгуулах			
		4. Албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын хэрэгжилтийн талаар сургалтыг зохион байгуулж ажилтан, албан хаагчдыг хамруулах	2017 оны 1 сард жуулчны мэдээллийн төвд албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын хэрэгжилтийг хангуулах мөн "Edoc" албан хэрэг хөтлөлтийн программ ашиглах тухай нийт албан хаагчдад сургалт орон гарын авлага тараасан болно. Мөн тус газарт шинээр ажилд орж байгаа албан хаагчид болон албан хэрэг хөтлөлтийн "Edoc" программтай холбоотой асуудлаар албан хаагчдад тухай бүр нь заавар зөвөлгөө өгч ажиллаж байна.		
	Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлж ажиллана.	Аялал жуулчлалын байгууллага болон жуулчдад үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцын үйл ажиллагаа эрхлэх журам"-ын дагуу жуулчны байр сууцын үйлчилгээ эрхлэгчдээс 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 194 санал хүсэлт, өргөдөл ирсэн ба стандартын шаардлага хангасан 33 иргэн, 132 ААН-д үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож, стандартын шаардлага хангаагүй 3 иргэн, 16 ААН-д хугацаатай үүрэг даалгавар өгч, стандартын үзлэгт хамрагдах хүсэлтэй 1 иргэн, 9 ААН-ийн хүсэлтийн дагуу үзлэгт хамруулахаар бэлтгэлийг хангаж байна. Иргэд, ААН-ээс зочид буудал, дэн буудал, амралтын газрын зөвшөөрөл хүссэн өргөдлийн дагуу стандартын үзлэг шалгалтыг санал хүсэлт ирснээс хойш 9 хоногт багтаан шийдвэрлэдэг. Сард 1 удаа газрын хурлыг тогтмол зохион байгуулж иргэд, ААНБ-уудаас ирсэн санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн явцын мэдээллийг танилцуулж хяналт тавин ажиллаж байна. 2017 оны эхний хагас жилийн байдлаар хугацаа хоцорч шийдвэрлэсэн санал, хүсэлт байхгүй байна. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авч, олгож байна.	Захиргааны хэлтэс	50%
		Жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийгэм, соёлын нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд	- Монголын Зочид Буудлуудын Холбоо, Нийслэлийн Аялал жуулчлалын газар болон Байгаль орчин Аялал жуулчлалын яамтай хамтран "HORECA ULAANBAATAR EXPO 2017" үзэсгэлэнг 2017 оны 4 сарын 13-15-ны өдрүүдэд "Корпорейт Конвеншн төв"-д зохион байгууллаа. Энэ удаагийн үзэсгэлэнд 60 гаруй зочид		



		<p>чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах</p>	<p>буудал, ресторан зоогийн газар болон хүнс үйлдвэрлэгчид, импортлогч компаниуд бараа бүтээгдэхүүн, үйл ажиллагаагаа танилцуулав.</p> <p>- Гэрлэх ёслолын ордонг хотын аяллын бүтээгдэхүүн болгох зорилгоор Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ-тай хамтарч ажиллах Санамж бичгийг 2017 оны 05 сарын 15-ны өдөр байгуулав. Санамж бичгийн хүрээнд 2017 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган батлав. Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ-аас ирүүлсэн хөтөлбөр, танилцуулгыг Үндэсний аялал жуулчлалын Улаанбаатар үзэсгэлэнгийн үеэр сурталчлан, аялал жуулчлалын компаниудад хүргүүлж аяллын хөтөлбөрт оруулах ажлыг хийж байна.</p> <p>- Монголын үндэсний өв соёл, уламжлалыг гадаад сурталчлах зорилготой Монгол фильм группын бүтээл Чингисийн хүүхдүүд уран сайхны киног жуулчны улирлын туршид “Corporate cinema” болон “Icinema” кино театраар өдөр бүр тодорхой цагуудад гаргаж жуулчдад үзүүлэх аяллын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болгон сурталчлах ажилд аялал жуулчлалын байгууллагуудын 60 гаруй төлөөллийг хамруулав.</p> <p>- Улаанбаатар хотыг олон улсад өрсөлдөх чадвартай, зүүн хойд Азийн бизнес, соёлын болон дамжин өнгөрөх жуулчлалын төв болгон, ирсэн жуулчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрөөх аялал жуулчлалын олон талт үйлчилгээ бий болгох зорилготой Шөнийн гэрэлт гудамж төслийг хэрэгжүүлж байна. Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/390, А/496 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2017 оны А/104 дүгээр тушаалын дагуу “Шөнийн гэрэлт гудамж” төслийн хүрээнд төсөл хэрэгжих байршилд асар болон зориулалтын бусад түр байгууламжаар худалдаа, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжүүд, хоол үйлдвэрлэл үйлчилгээ, хүнсний худалдаа</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/36 дугаар захирамжаар 02-р сарын 11,12-ны өдрүүдэд “Улаанбаатарын өвлийн наадам 2017” арга хэмжээг НЗДТГ, НОБГ, НСУГ, БТСХ, БЗД-ын ЗДТГ, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨҮГ, “Улаанбаатар чуулга”, Хот тохижилтын газар, Мөсөн шагайн холбоо, Мөсөн сурын</p>		
--	--	--	--	--	--

			<p>холбоо, Мэргэжлийн сноубордын холбоо, Регбигийн холбоо, Цанын холбоо, "Зайсан мото" клуб, Үндэсний хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний нэгдсэн холбоо зэрэг 16 байгууллагуудтай хамтран Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгууллаа.</p> <p>- Монголчуудын уламжлалт соёл түүний дотор үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет бус өвийг гадаад, дотоодод сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор "Дээлтэй Монгол наадам" арга хэмжээг 07 сарын 10-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. "Дээлтэй Монгол" наадмын баярын параданд Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянгол, Чингэлтэй, Багахангай, Налайх дүүргүүд, Хүүхэлдэйн театр, Нийслэлийн гэрлэх ёслолын ордон, "Мөнхтэнгэр оньс" төв, "АПУ" ХК, "Амин тоонто" ТББ, Монголын Сурагчдын холбооны төлөөлөл оролцлоо.</p>		
		<p>Аялал жуулчлалыг зохистой хөгжүүлэх чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах</p>	<p>1. "Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх хөтөлбөр"-ийн төслийг 2017 оны 06 сарын 15-ны өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, НИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр, өргөн барихаар ажиллаж байна. "Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн төсөлд байгууллагын <a href="http://www.tourism.ub.gov.mn">www.tourism.ub.gov.mn</a> цахим хуудасд санал асуулгын цэс байршуулж иргэдээс санал авч байна. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамааралтай байгууллагууд болох ЗАА, НЦГ, НХТЕТГ, НСУГ, НБТСХ зэрэг байгууллагуудаас албан бичгээр санал авсан болно.</p> <p>2. Албан болон бизнесийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг байгуулах талаар Байгаль орчин, Аялал жуулчлалын яам болон аялал жуулчлалын байгууллагуудын төлөөлөл оролцсон уулзалтыг 2017 оны 05 сарын 01-ний өдөр Holiday Inn зочид буудлын хурлын танхимд зохион байгуулав. Уулзалтын үеэр "MICE, ажил хэргийн аялал жуулчлалын зах зээл" сэдвээр Bat Solutions Partners ХХК-ийн ерөнхий захирал Б.Баярхүү, "MICE зах</p>	Бодлого төлөвлөлтийн хэлтэс	
		<p>Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах, УБ хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийн төсөл боловсруулах, үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөмж, санал дүгнэлтийг тусгах ажлыг зохион</p>			

		байгуулах	зээлийн хэв шинж” сэдвээр Үндэсний Аялал жуулчлалын байгууллага ТББ-ын тэргүүн Б.Индра нар илтгэл тавьж, илтгэлүүдтэй холбоотой асуулт, хариулт хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгийн дараа хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга С.Бат-Эрдэнэ, тус яамны мэргэжилтэн С.Баясгалан, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх, тус газрын мэргэжилтэн Д.Жавхлан, Монголын Зочид буудлуудын холбооны ерөнхийлөгч С.Мөнхбат, Үндэсний Аялал жуулчлалын байгууллагын тэргүүн Б.Индраа, Bat Solutions Partners ХХК-ийн ерөнхий захирал Б.Баярхүү, Улаанбаатар Аялал жуулчлалын холбооны тэргүүн Ё.Бадрал, WTM ХХК-ны менежер Э.Цэрэндолгор нарын нэрийг дэвшүүлсэн. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын тушаалаар батлуулахаар хүлээгдэж байна.		
		Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах ажлыг хариуцан зохион байгуулах, энэ чиглэлээр маркетингийн стратеги, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөрийг 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр газрын даргаар батлуулж төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд нийт 14 ажил хийхээр тусгагдсан.	Мэдээлэл сурталчилгааны хэлтэс	
		Гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон ТББ-тай хамтран ажиллах	Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх, цагдаагийн албан хаагчдын гадаад хэлний мэдлэг, ур чадварыг сайжруулах, олон нийтийн арга хэмжээний үед болон Горхи, Тэрэлжийн бүс нутаг, Туул голын сав газраар морин, завьт, машинт эргүүл ажиллуулах, жуулчны бааз, амралтын газар, шөнийн клуб, ресторан, паб, зочид буудал зэрэг газруудын харуул, хамгаалалтыг өндөржүүлэх чиглэлээр Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Цагдаагийн газартай 2017-2020 онд хамтран ажиллах Санамж бичгийг 2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр байгуулан НЦГ-ын дэргэдэх Олон нийтийн цагдаагийн тасаг, Монголын Оюутны холбоотой хамтран ажиллаж байна	Захиргааны хэлтэс	
		Аялал жуулчлалын	-	Захиргаа-	

		салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтийг төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулах, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод сургалтад хамруулж, мэргэшлийг дээшлүүлэх		ны хэлтэс Бодлого төлөвлөлтийн хэлтэс
		Улаанбаатар хоттой хамтын ажиллагаатай хотуудтай аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, нийслэл хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах	<p>- ХБНГУ-ын Берлин хотноо 2017 оны 3 сарын 04-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Ай-Ти-Би Берлин олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/97 дугаар захирамжийн дагуу тус газрын дарга Д.Батсүх, мэргэжилтэн Я.Сарангэрэл нар оролцов.</p> <p>- Оросын Холбооны улсын “Байкалтур-2017” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 20 дахь жилдээ Эрхүү мужийн “Сибэкспоцентр” төвд 2017 оны 03 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд “Их цайны зам” сэдвийн хүрээнд зохион байгуулагдав. Монгол Улсын аялал жуулчлалыг олон улсад сурталчлан таниулах, ах дүү хотуудын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, Улаанбаатар хотыг чиглэсэн жуулчдын урсгал болон дамжин өнгөрөх тоог нэмэгдүүлэх зорилготой энэхүү үзэсгэлэнд Монгол улсаас ОХУ-ын Эрхүү мужид суугаа Ерөнхий консул Л.Амарсанаа оролцож нээлтийн үйл ажиллагаанд үг хэлсэн. Тус үзэсгэлэнд Улаанбаатар хотыг төлөөлж Нийгмийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч, нийслэлийн засаг даргын орлогч Ш.Анхмаа, тус газрын дарга Д.Батсүх болон бусад ажилтнууд оролцож, Улаанбаатарын Аялал жуулчлалын холбоо, UBS телевиз, Зочид буудал, тогооч нарын холбооны төлөөллүүд, аялал жуулчлалын 8 компани хамтран Монгол улсаа сурталчиллаа.</p> <p>- Нийслэлд аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн Аялал жуулчлалын газар, БНСУ-ын Чөжүгийн Аялал жуулчлалын газар хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд Нийслэл хот орчмын амралт, аялал жуулчлалын бүсэд</p>	Бодлого төлөвлөлтийн хэлтэс

			явган аяллын зам тохижуулах заалт тусгагдсан. Хамтын ажиллагааны гэрээний дагуу БЗД-ийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэр Богдхан ууланд 2 явган аяллын зам дагуу нийт 120 туузтай багана, эхлэл төгсгөл цэг дээр морь хэлбэрт 8 тэмдэг, 2.2 өндөртэй том самбар 2-ыг тус тус байрлуулж тохижуулав.	
	Аялал жуулчлалын байгууллагуудын дунд аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрөл бүрийн сургалт зохион байгуулах		<p>- Монголын Хөтөч тайлбарлагчдын холбоотой хамтран 2017 оны 04 сарын 05-наас 05 сарын 05 хүртэл хугацаанд “Хөтөч тайлбарлагчдын чадваржуулах” сургалтыг зохион байгуулав. Сургалтад 43 хүн хамрагдаж, шалгалтад тэнцсэн 16 хүнд Хөтөч мэргэжлийн сертификат олгов.</p> <p>- Гадаад хэлний зохих мэдлэгтэй оюутан, хөдөлмөр эрхлээгүй залуучуудын ур чадварыг сайжруулах, аялал жуулчлалын салбарт хөдөлмөр эрхлэх бололцоотой боловсон хүчнийг нэмэгдүүлэх, тэдгээрийн мэргэшил, мэдлэгийг сайжруулах, гадаадын жуулчдад үйлчлэх аяллын хөтчийг мэргэжлийн арга зүйгээр хангах зорилгоор Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газартай хамтран “Гадаадын жуулчны хөтөч бэлтгэх” сургалтыг 2017 оны 05 дугаар сарын 26-наас 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэл 5 хоногийн хугацаанд зохион байгуулав. Нийт 600 гаруй хүн бүртгүүлснээс 326 хүн сургалтад хамрагдаж, 282 хүн амжилттай суралцаж, батламж авлаа.</p> <p>- Нийслэлийн харьяа газар, агентлагийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүд, тус газрын ажилтнуудад зориулсан “Виз болон гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах тухай журам” сэдэвт сургалтыг 2017 оны 3 сарын 14-ний өдөр Хангазрьд ордонд ЗДТГ-ын Гадаад харилцааны хэлтэстэй хамтран зохион байгуулав. Сургалтад “Монгол Улсын иргэн гадаад улс оронд зорчих, “Гадаадын иргэн, жуулчид Монгол Улсад зорчих” сэдвийн хүрээнд ГХЯ-ны Консулын газрын орлогч захирал Л.Мөнхтүшиг, “Гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам” сэдвээр ГХЯ-ны 2 дугаар нарийн бичгийн дарга Д.Батбилэг, Консулын газрын мэргэжилтэн Ц.Майцэцэг нар мэдээлэл өгөв.</p>	Захиргааны хэлтэс
	Гадаад, дотоодын	Жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах зорилгоор	Мэдээлэл	

		жуулчдыг хэрэгцээт мэдээллээр шуурхай хангаж, УБ хотын талаарх сурталчилгааны материалуудыг тогтмол шинэчлэх арга хэмжээ авч ажиллах	Улаанбаатар хотын газрын зураг 10.000 ширхэг хэвлүүлэв. “Улаанбаатар жуулчны хөтөч” гарын авлага номыг 6.800 ширхгийг хэвлүүлэхээр Колорфул ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Нийслэл Масс Медиа” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан хөтөч номын эх бэлтгэл, загварыг хийж, текстийг редакторлах ажлыг дуусгаж хэвлэлтэд ороход бэлэн болгов.	сурталчилгааны хэлтэс	
		Гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн үзэсгэлэн, арга хэмжээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа ААНБ-уудыг хамруулах	Оросын Холбооны улсын “Байкалтур-2017” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 20 дахь жилдээ Эрхүү мужийн “Сибэкспоцентр” төвд 2017 оны 03 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд “Их цайны зам” сэдвийн хүрээнд зохион байгуулагдав. Монгол Улсын аялал жуулчлалыг олон улсад сурталчлан таниулах, ах дүү хотуудын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, Улаанбаатар хотыг чиглэсэн жуулчдын урсгал болон дамжин өнгөрөх тоог нэмэгдүүлэх зорилготой энэхүү үзэсгэлэнд Улаанбаатарын Аялал жуулчлалын холбоо, UBS телевиз, Зочид буудал, тогооч нарын холбооны төлөөллүүд, аялал жуулчлалын 8 компани хамтран Монгол улсаа сурталчиллаа.	Мэдээлэл сурталчилгааны хэлтэс,  Захиргааны хэлтэс	
		Жуулчдад зориулсан мэдээлэл сурталчилгааны төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дэргэдэх Сөүлийн гудамжинд байрлах Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Иргэдэд үйлчлэх төвийн “Жуулчны мэдээллийн төв”-ийн “Шударга худалдаа, жуулчны мэдээллийн цэг” /Tourist information and Fair trade center/-ийн үйл ажиллагааг сайжруулах, Шөнийн гэрэлт гудамж төслийг хэрэгжүүлж байгаатай холбогдуулан Сөүлийн гудамжинд Гэр мэдээллийн төвийг тохижуулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/380 дугаар захирамжийн дагуу “Түмэн Цагаан Гэр” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, 2 ширхэг авдар, 1 ширээ, 8 сандал, 1 брошурын тавиурыг тус тус захиалан хийлгэж, Эм Пи Эм ХХК-иас 90х170 хэмжээтэй /газрын зураг/ 2 ширхэг, 120х230 хэмжээтэй /газрын зураг/ 1 ширхэг нийт 3 ширхэг Улаанбаатар хотын газрын зураг худалдан авч мэдээллийн төвүүдэд байршуулав.	Мэдээлэл сурталчилгааны хэлтэс	
		Жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, тэдгээрийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Улаанбаатар хотын түүхэн болон орчин үеийн 6 ширхэг гэрэлт зургийг Сөүлийн гудамжинд байрших Гэр мэдээллийн төвийн хананд байршуулж, UNIPRESS ХХК-иар мэдээллийн төвийн гаднах хаягыг Англи болон		
		Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа			

		байгууллагуудыг бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтлөх	Монгол хэл дээр хийлгэж суурилуулсан. Жи-Мобайл ХХК-тай гэрээ байгуулж интернетийн холболт хийж мэдээллийн төвийг интернет сүлжээнд холбож, КоллПро ХХК-тай хамтран ажиллах гэрээ сунгаж, мэдээллийн төвийн суурин утас, дуудлага хадгалах үйлчилгээ, автомат хариулагч зэргийг үргэлжлүүлэн ашиглалтад оруулав. Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны байранд “Шударга худалдаа, жуулчны мэдээллийн цэг”-ийг ажиллуулах түрээсийн гэрээг 2017 оны 06-р сарын 01 -нээс 12-р сарын 31 хүртэл хугацаатайгаар байгууллаа. 2017 оны 06 болон 07-р саруудад зохиогдох соёл урлагийн тоглолтуудын хуваарийг шинэчлэв.		
		Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад эрхэлсэн асуудлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгөх	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Монгол Улсын Засгийн газрын тогтоолын биелэлт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, НИТХ-ын 2016 оны 5/10 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, НИТХ-ын 2017 оны тогтоолын биелэлт, НИТХТ-ийн 2017 оны тогтоолын биелэлт, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлтийг хагас жилийн байдлаар гарган НЗДТГ-ын ХШҮХ, БТХ, ХЭЗХ-т тус тус хүргүүлэв.	Бүх хэлтсүүд	
		Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах	Нийслэл хотын зочид буудал, дэн буудлуудын үйлчилгээний чанар, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, жуулчдын аюулгүй байдлыг хангах, зочлох үйлчилгээний салбарын эрхлэгч, менежер, ажилтнууд, жуулчидтай шууд харилцдаг төрийн байгууллагын ажилтнуудад зориулж үйлчилгээний чанар, стандарт, аюулгүй байдал, харилцааны соёл, хөтөч-тайлбарлагчийн зэрэг сургалтуудыг зохион байгуулах болон тус газраас жуулчдад зориулсан аялал жуулчлал, спорт, соёл урлагийн арга хэмжээг аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын төлөөлөл бүхий хувийн хэвшилтэй хамтран	Захиргааны хэлтэс	

			хэрэгжүүлэх үүднээс 2017 оны хагас жилийн байдлаар 5 төр болон ТББ, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагааны Санамж бичиг, 51 хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна.		
НИЙТ				50%	

ТАНИЛЦСАН:  
ДАРГА

Д.БАТСҮХ

ХЯНАСАН:  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ГАНБОЛД

БОЛОВСРУУЛСАН:  
МЭРГЭЖИЛТЭН

Э.МӨНХЗУЛ



